

“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, БЗД, 13-р хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 23-01 тоотод байрлах “Багануур-Илч” ХХК-ийн 2 давхарт хурлын танхимд хуралдав.

ХУРЛЫН ИРЦ: Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох санал ирээгүй, 20,147,606 ширхэг хувьцааг төлөөлж 2 хүн итгэмжлэлээр, 2,908 ширхэг хувьцаа эзэмшигч 8 хүн өөрийн биеэр нийт 20,150,526 хувьцаа эзэмшигч оролцож хурал 96,07 хувийн ирцтэй хуралдав.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН

Д/д	Нэр	Албан тушаал
1	Г.Соёлмаа	Хурал зохион байгуулах комиссын дарга, “Багануур” ХК-ийн Төлөөлөгчийн газрын менежер
2	Б.Одгэрэл	Багануур ХК-ийн хуулийн зөвлөх
3	У.Батсуурь	“Багануур Илч” ХХК-ийн Гүйцэтгэх захирал
4	С.Одончимэг	Хэвлэл мэдээллийн ажилтан
5	Г.Мөнгөнтуул	“Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирлын туслах
6	Б.Хажидмаа	Тооллогын комиссын дарга, “Багануур” ХК-ийн ДХША-ны дарга
7	Д.Даваадаш	Тооллогын комиссын гишүүн, “Багануур” ХК-ийн СЭЗБХ-ийн эдийн засагч
8	Б.Жаргал	Тооллогын комиссын гишүүн, “Багануур” ХК-ийн СЭЗБХ-ийн эдийн засагч

ХУРАЛД ОРОЛЦСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:

- | | |
|-------------------|---|
| 1. С.Наранцогт | Хувьцаа эзэмшигч “Эрдэнэс Монгол” ХХК |
| 2. Ч.Даваадолгор- | Хувьцаа эзэмшигч “БИДИСЕК ҮЦК” ХК |
| 3. Б. Гэрлээ- | Хувьцаа эзэмшигч “Эрдэнэс Монгол” ХХК |
| 4. М.Отгонбаяр- | Хувьцаа эзэмшигч /Монголиан нейшнл коүл
корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч |
| 5. С.Уранчимэг | Хувьцаа эзэмшигч |
| 6. Э.Энхжаргал | Хувьцаа эзэмшигч |
| 7. С.Пүрэвжав | Хувьцаа эзэмшигч |
| 8. С.Мягмарсүрэн | Хувьцаа эзэмшигч |
| 9. О.Эрдэнэбилэг | Хувьцаа эзэмшигч |

10. С.Бямбасүрэнгийн	Хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Долоонбаяр
11. М.Байгалмаа	Хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч О.Эрдэнэбилэг
12. Ж.Цэдэнсодном	Хувьцаа эзэмшигч
13. Г.Алтан-Оч	Хувьцаа эзэмшигч
14. Ж.Энхтунгалаг	Хувьцаа эзэмшигч

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ТАНИЛЦУУЛСАН:

- | | |
|-------------------|---|
| 1. Д.Түвшинжаргал | “Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч |
| 2. Т.Ариунболд | “Багануур” ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч |
| 3. Д.Даваасүрэн | Эрчим хүчний яам, ТУЗ-ийн гишүүн |
| 4. Осоргарав | ТУЗ-ийн аудитын хорооны дарга |

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга,
4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай
6. Компанийн дунд хугацааны төлөвлөгөөний танилцуулга
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Б.Хажидмаа /Тооллогын комиссын дарга/ : “Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг танилцуулав. Хуралдааны ирц бүрдсэн тул хурлыг хуралдуулахыг зөвшөөрч байна

Д.Даваасүрэн /Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооны гишүүн/: 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01 дугаартай тогтоолыг уншиж танилцуулан өнөөдрийн хуралдааны даргалагчаар С.Наранцогтыг томилсныг танилцуулав.

С.Наранцогт/ Хуралдаан даргалагч/: Хурлыг нээж хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав. Нэгдүгээр асуудал болох Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулгыг танилцуулна уу.

Д.Түвшинжаргал /Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч/: Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав. Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд: 2022 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр нүүрс гаргалт, борлуулалтын төлөвлөгөө 101.4 хувь, хөрс хуулалтын төлөвлөгөө 104.4 хувь, нийт уулын цулын төлөвлөгөө 108.0 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн.

Тайлант онд компанийн орлогын төлөвлөгөө 102.9 хувь, зардлын төлөвлөгөө 98.9 хувь, ашиг ажиллагааны түвшин 83.4 хувь буюу төлөвлөсөн алдагдлыг 6.8 тэрбум төгрөгөөр бууруулан ажиллаа.

Бодлогын чанартай хийсэн ажлууд: 2022 онд компани Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын хэрэгжилтийн хүрээнд “Мон Сертф” ХХК-ийн аудитын багаар аудит хийлгэж гэрчилгээгээ хадгалж үлдлээ.

Түүнчлэн Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Улсын комиссын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 22/01 тоот актаар жилд арван сая тонн нүүрс олборлон борлуулах төслийн хүчин чадлаар уурхайг цаашид үргэлжлүүлэн явуулах боломжтой гэсэн зөвшөөрөл олгосон.

40 жил ашигласан уулын дэд станцыг нүүлгэн шилжүүлэх ажлыг дуусгаж 110/6 квт-ын уулын шинэ дэд станцыг хүлээн авч ашиглалтад орууллаа.

Тайлант онд “Төрийн хэмнэлтийн тухай” хууль гарсантай холбоотой тус хуультай шууд холбоотой 0.66 тэрбум төгрөг, хөрс хуулалтын хэмжээг өмнөх жилүүдээс 4.4 сая.м3-ээр бууруулж 10.7 тэрбум төгрөг, компани дотооддоо хэмнэлтийн ажил зохион байгуулж 1.9 тэрбум төгрөгийг хэмнэснээс гадна, худалдан авалтын ажлыг оновчилсны дүнд төлөвлөгөөг 9.0%-аар буюу 8.8 тэрбум төгрөгөөр хэмнэн ажиллаа.

2023 онд хийх ажлын талаар: 2023 онд 16,900.0 мян.м3 хөрс хуулж, 5,300.0 мян.м3 ус шавхан зайлуулж, 4,500.1 мян.тн нүүрс олборлож, нийт 27,129.4 мян.м3 уулын цулын ажлыг хийхээр төлөвлөгөөг боловсрууллаа. Өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс хөрс хуулалт 746.5 мян.м3, үүнээс тээвэргүй хөрс хуулалт 502.3 мян.м3-ээр буурсан бол авто хөрс хуулалтын хэмжээ 1,248.6 мян.м3-ээр буурч байна.

2023 онд 203 тэрбум 899.3 сая төгрөгийн орлого олж 219 тэрбум 466.2 сая төгрөгийн зардал гарган, 15 тэрбум 566.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөж байна.

2023 онд Эрчим хүчний зохицуулах хороо болон холбогдох эрх бүхий байгууллагуудад нүүрсний үнэ нэмэгдүүлэх хүсэлтийг тавьж шийдвэрлүүлэх, МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт туссан тоног төхөөрөмжүүдийн шинэчлэлд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх, МУ-ын Засгийн газрын 2018 оны 132 тоот тогтоолд дурдсан “Монгол нүүрс” төслийн зээлийг хөрөнгө оруулалтаар бүртгүүлэх, толгой болон групп компанийн удирдлагуудтай хамтран үр ашигтай төслүүдийн тооцоог хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байгаа талаарх мэдээллийг тус тус танилцуулав.

Д.Даваасүрэн /Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооны гишүүн/: Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийг уншиж танилцуулав.

Асуулт: Хувьцаа эзэмшигч О.Эрдэнэбилэг: Компанийн тайлантай танилцлаа, нүүрсний үнэ нэмэгдээгүйн улмаас тонн тутамдаа хэдэн төгрөгийн алдагдал хүлээсэн бэ?

Хариулт: Д.Түвшижаргал Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч: Үнийн зөрүүний алдагдал 33 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн.

Асуулт: Хувьцаа эзэмшигч О.Эрдэнэбилэг: Лиценз хэний эзэмшилд байдаг вэ?

Хариулт: Д.Түвшижаргал Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч: “Багануур” ХК болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэр дээр байдаг.

Хувьцаа эзэмшигч О.Эрдэнэбилэг: Лицензээ өөрийн компанийн нэр дээр шилжүүлж авах, Дизель түлш, тэсрэх материалын үнэ огцом өссөнтэй холбогдуулан 44 тэрбум төгрөгийн үнийн зөрүү гарсан байна, энэ байдал дээр анхаарч сайн ажиллаарай гэв. Хуралд танилцуулсан материалыг хавсаргав.

Б.Гэрлээ Хувьцаа эзэмшигч: “Эрдэнэс Монгол” ХХК-аас ирүүлсэн удирдамжийг уншиж танилцуулж, компанийн үйл ажиллагааны тайланд “Сайжруулах шаардлагатай” гэж дүгнэлт өгч тогтоол гаргахаар тогтов.

Хурал даргалагч С.Наранцогт: Хоёрдугаар асуудал болох “Багануур” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудлыг танилцуулна уу.

Ерөнхий нягтлан бодогч Т.Ариунболд: “Багануур” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд өгсөн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг танилцуулав.

Аудитын тайлан. Хязгаарлалттай дүгнэлт

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзэж санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Багануур ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулаагүй дараах алдаа, зөрчил нь тогтоосон 1,509.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давж, санхүүгийн тайлагналд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Үүнд: Авлагын 3,234.8 сая, өглөгийн 9,407.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 71,8 сая төгрөгийг зарцуулсан, ТБОНӨХБАҮХА тухай хуулийг зөрчиж 10,820.3 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн.

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж.

Дансны авлага. 157 харилцагчийн 3,234.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна.

Дансны өглөг 9,407.3 сая төгрөгийн дансны өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажаагүй байна.

ЭМД шимтгэл ажилтнаас төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 1 хувь буюу 375.9 сая төгрөгийг компани хариуцаж байна.

Хөрөнгө шилжүүлэх Шивээ овоо ХК-руу 263.4 сая төгрөгийн өртөг бүхий алхагч экскаваторын эд ангийг эргэн төлөх нөхцөлөөр шилжүүлсэн.

Авлага өглөг хаах авлага өглөгийн тооцооны үлдэгдлийг харилцагч 2 компанийн албан бичгийг үндэслэн хаасан.

Дараа тайлангаар бэлэн мөнгө олох, тооцоог хаах журмын дагуу тайланг хугацаанд нь хаахгүй байна.

Худалдан авалтын хууль зөрчсөн 10,820.3 сая төгрөгийн худалдан авалт байна.

Хэмнэлтийн хуулийг зөрчин ажилтнуудыг танхимын сургалтуудад хамруулсан 8.52 сая төгрөг, Төрийн одон медаль хүртсэн ажилтнууд, ойн арга хэмжээ, тэмцээн уралдаан, шагнал дурсгалд 64.3 сая төгрөг зарцуулсан.

Зөвлөмжийн дагуу хийх ажлууд.

Авлагын тооцоо нийлээгүй байгууллагуудтай тооцоо нийлэх, 2023 оны 3 дугаар улиралдаа авлагын тооцоо нийлэх ажлыг эрчимжүүлнэ, шаардлагатай тохиолдолд нэмэлт ажилтан хуваарилж ажиллана.

Өр төлбөртэй компаниудтай тооцоо нийлэх 2023 оны 3 дугаар улиралдаа өглөгийн тооцоо нийлэх ажлыг эрчимжүүлнэ, тооцоо нийлсний дараа өр төлбөрийг шилжүүлэх,

ҮЭНХ-той хамтын гэрээг шинэчлэн баталж нийгмийн даатгалын тухай хуульд нийцүүлнэ.

Хуралд танилцуулсан материалыг хавсаргав.

Хурал даргалагч С.Наранцогт: Гуравдугаар асуудал хэлэлцэх Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлтийг танилцуулах

ТУЗ-ийн аудитын хорооны дарга Б.Осоргарав Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлтийг танилцуулав.

Б.Гэрлээ Хувьцаа эзэмшигч: “Эрдэнэс Монгол” ХХК-аас ирүүлсэн удирдамжийг уншиж танилцуулж, компанийн санхүүгийн тайланд “сайжруулах шаардлагатай” гэж дүгнэлт өгч тогтоол гаргахаар тогтов.

Зөвлөмж:

1. Компанийнхаа 2022 онд олсон ололт амжилтыг улам бататгаж, урьд урьдаас илүү амжилт гаргахын төлөө удирдлага, захиргааны ажилтнуудын хүч, нөөц, бололцоог бүрэн чиглүүлэн, ажилтан, ажилчдынхаа ажиллах урам, зориг, идэвх санаачилгыг

- улам өрнүүлэхэд анхаарч, хөдөлмөр зохион байгуулалтаа боловсронгуй болгон ажиллах.
2. Компанийнхаа орлогыг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэхийн тулд, дотооддоо нийлүүлэх нүүрсээ нэмэгдүүлэхийн зэрэгцээ, гадаадад нүүрсээ экспортлох боломж, бололцоог эрэлхийлж, энэ талаар идэвх санаачилга гарган ажиллаж, үр дүнд хүрэх.
 3. Компанийнхаа алдагдалтай ажиллаж байгаа учир шалтгаанаа, үндэслэл тооцоо сайтайгаар боловсруулан, дотоодод борлуулж байгаа нүүрснийхээ үнийг 3.0-5.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх санал хүсэлтийг "Эрдэнэс монгол" компаниар дэмжүүлэн холбогдох дээд байгууллагуудад цаг алдалгүй, удаа дараа тавьж шийдвэрлүүлэх.
 4. Компанийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын дүгнэлт, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, цаашид зөрчил, дутагдал гаргахгүй ажиллахад анхаарах.

Хурал даргалагч С.Наранцогт: Дөрөвдүгээр асуудал болох ногдол ашиг хуваарилах эсэх талаар гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн 01 дугаартай тогтоолыг уншиж танилцуулав.

Хурал даргалагч С.Наранцогт: Тогтоолтой холбогдуулан Хувьцаа эзэмшигчид тодруулж асуух асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигчид: Асуултгүй байхгүй.

Хурал даргалагч С.Наранцогт: Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг танилцуулна уу

Д.Түвшинжаргал Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч: Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай танилцуулав.

Компанийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтөөр: Компанийн дүрэм нь 6 бүлэг 58 зүйлтэй бөгөөд шинэчилсэн дүрмийн бүтэц нь

Нийтлэг үндэслэл

Компанийн хувьцаа, ногдол ашиг

Компанийн засаглалын тогтолцоо

Компанийн санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хяналт

Бусад асуудлууд гэсэн 6 бүлэгтэй.

Дүрмийн өөрчлөлтийн онцлог нэмэлт заалт нь:

1.2 Компанийн зорилго, үйл ажиллагааны чиглэл

Компани нь байгаль орчинд ээлтэй сөрөг нөлөөгүй дэвшилтэт техник, технологийг ашиглан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж, хэрэглэгчдийг стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн үр ашигтай бизнес эрхлэхийг үндсэн зорилгоо болгох,

Компанийн засаглалын тогтолцоо

Менежментийн гэрээ байгуулах, төлбөр авах үндэслэлийг бий болгосон

Компанийн бүтэц дэх нэгдсэн стратеги төлөвлөлт, санхүүгийн нэгдсэн удирдлага, мэдээллийн технологийн асуудал хариуцсан бүтцийн нэгжийн удирдлагыг толгой компанийн саналаар томилно.

Төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газар, УИХ, ҮАБ-ын зөвлөлд танилцуулах шаардлагатай асуудлаа толгой компаниар дамжуулан танилцуулж, шийдвэрлэнэ.

Компани нь үйл ажиллагааны үр дүн, ажлын тайлангаа хувьцаа эзэмшигчид жилд хоёроос доошгүй удаа шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчийн шаардсанаар тухай бүр танилцуулахаар өөрчлөлт оруулсан байна.

Хурал даргалагч С.Наранцогт: Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдэд асуулт байна уу?

Асуулт: Хувьцаа эзэмшигч Т.Отгонбаяр: Энэ дүрмийн төсөлд Толгой компаниар дамжуулан асуудлыг шийдвэрлүүлнэ гэж байна, энэ талаар тайлбар өгнө үү, яг юуг шийдвэрлүүлэх вэ?

Хариулт: Хурал даргалагч С.Наранцогт: “Багануур” ХК нь асуудал шийдвэрлүүлэх гэж “Эрдэнэс Монгол” ХХК, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар гэх мэт олон газар руу ханддаг энэ асуудлыг нэг талд нь гаргахаар дээрх заалтыг оруулсан бөгөөд нэг үгээр хэлбэл төрийн дээд шатны байгууллага холбогдоод байхгүй “Эрдэнэс Монгол” ХХК нь “Багануур” ХК-ийн өмнөөс нь холбогдох асуудлуудыг шийдвэрлүүлдэг болно.

Асуулт: Хувьцаа эзэмшигч Т.Отгонбаяр: Компанийн бүтэц дэх нэгдсэн стратеги төлөвлөлт, санхүүгийн нэгдсэн удирдлага, мэдээллийн технологийн асуудал хариуцсан бүтцийн нэгжийн удирдлагыг толгой компанийн саналаар томилно гэж байна, энэ нь компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд саад учруулах, Гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд хэтэрхий их нөлөөлөөд байгаа юм биш үү?

Хариулт: Хурал даргалагч С.Наранцогт: Монгол Улсын Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу уг заалтыг оруулсан бөгөөд Толгой компанийн саналыг үндэслэн томилно гэж заасан байгаа.

Хувьцаа эзэмшигчид: Өөр асуултгүй гэв.

Хурал даргалагч С.Наранцогт: Хурлын дэгийн дагуу хурлын үйл ажиллагаа 15 минут завсарлаад 13 цаг 40 минутад хуралдаан үргэлжилнэ

Хурал даргалагч С.Наранцогт: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай танилцуулна уу

ТУЗ-ын гишүүн Д.Даваасүрэн: Засгийн газрын 2023 оны 84-р тогтоолоор батлагдсан журмын дагуу Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлс,

урамшууллын хэмжээг салбар дундын хамтын хэлэлцээрээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний цалин олгох, ТУЗ-ийн хороодод ажилласан тохиолдолд үндсэн цалингийн дөрөвний нэгтэй тэнцүү хэмжээний нэмэгдэл тооцон олгох талаар танилцуулав.

Хурал даргалагч С.Наранцогт: Хувьцаа эзэмшигчид Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудлын хүрээнд асуух асуулт байна уу

Хувьцаа эзэмшигч Т.Отгонбаяр: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хуралдаа суусан байдлаар тогтоож олгох зүйтэй гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч Ж.Цэдэнсодном: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хуралд суусан байдлаар тогтоож байх нь зүйтэй, мөн Багануур ХК-ийг ашигтай ажиллуулах тал дээр онцгой анхаарч жижиг хувьцаа эзэмшигчид ноогдол ашиг хуваарилах тал дээр онцгой анхаарч ажиллана уу, өмнө 2 удаа л ногдол ашиг авч байсан, тэрнээс бусад үед дандаа алдагдалтай ажиллаж байна.

ТУЗ-ын гишүүн Д.Даваасүрэн: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох тухай тогтоолыг танилцуулж, тогтоолд Засгийн газрын 2023 оны 84-р тогтоолоор батлагдсан журмын дагуу Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлс, урамшууллын хэмжээг салбарын гурван талт хэлэлцээрт заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний цалин олгох саналыг дэмжиж, мөн хувьцаа эзэмшигчдээс “Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудлыг шинэчлэн тогтоохоор ажиллаж байгаа тул цаашид цалин хөлсний хэмжээг Эрдэнэс Монгол ХХК-д тогтоох эрхийг олгохоор тогтов.

Хурал даргалагч С.Наранцогт: Хувьцаа эзэмшигчдэд өөр асуултгүй бол дараагийн асуудлаа хэлэлцье. Зургаадугаар асуудал Компанийн дунд хугацааны төлөвлөгөө танилцуулах /компанийн лого, алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийн өөрчлөлт/ танилцуулах

Д.Түвшинжаргал Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч: Компанийн дунд хугацааны төлөвлөгөө танилцуулах /компанийн лого, алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийн өөрчлөлт/ танилцуулав.

Үүнд: 7 зорилт, 31 ажил, 5 жил

7 зорилтууд:

Удирдлага зохион байгуулалтын хөгжил

Бүтээгдэхүүн үйл ажиллагааны хөгжил

Хүний нөөцийн хөгжил

Санхүү эдийн засгийн хөгжил

Техник, технологийн хөгжил

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөгжил

Нийгмийн хариуцлагын хөгжил гэсэн зорилтуудыг тус тус танилцуулаад компанийн лого, алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийн танилцуулгыг танилцуулахад

Хурал даргалагч С.Наранцогт: С.Наранцогт: Компанийн дунд хугацааны төлөвлөгөө танилцуулах /компанийн лого, алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийн өөрчлөлт/ танилцуулгын талаарх хувьцаа эзэмшигчдэд асуулт байна уу?

Асуулт: Хувьцаа эзэмшигч О.Эрдэнэбилэг: Компанийн лого шинэчлэхэд хэдэн төгрөгийн зардал зарцуулах вэ?

Хариулт: Д.Түвшинжаргал Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч: Компанийн логог шинэчлэхэд зардал гарахгүй учир нь бид энэ ондоо захиалсан ажлын хувцас, бичгийн хэрэгсэл, бусад холбогдох материалаа хэрэглэж дуусгаад дараагийн захиалгадаа логогоо хэрэглээд явна гэж төлөвлөж байгаа тэгэхээр зардал гарахгүй гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч О.Эрдэнэбилэг: Компанийн логог шинэчлэх шаардлагагүй, цагаа олоогүй зүйл байна, төр засгаас хэмнэ, хэмнэлтийн тухай хуулиа хэрэгжүүл гэж шаардаж байхад улам зарлага гаргах гээд байна, тийм учраас дэмжихгүй гэв.

Хурал даргалагч С.Наранцогт: Хувьцаа эзэмшигчдэд өөр саналгүй бол дараагийн асуудлыг хэлэлцье. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох талаар танилцуулах

Д.Даваасүрэн нэр дэвшүүлэх хорооны гишүүн: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох талаар танилцуулгыг танилцуулав.

Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам” болон мөн өдрийн 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-д заасны дагуу “Багануур” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус болон төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүдийг сонгон шалгаруулах ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 06-18-ны өдрүүдэд нээлттэй зохион байгуулж шаардлага хангасан нэр дэвшигчдийн жагсаалтыг гаргасан болно. Үүнд:

№	Төлөөлөл	Нэр дэвшигчид	Албан тушаал	Мэргэжил
1	“Эрдэнэс Монгол” ХХК	Б.Гэрлээ	Хууль эрх зүйн газрын ахлах менежер	Эрх зүйч, эдийн засагч

2	ЗГХЭГ	Ч.Дондогмаа	Хууль эрх зүйн газрын дарга	Эрх зүйч
3	Эрчим хүчний яам	И.Лувсанцэрэн	Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Цахилгааны инженер
4	Эдийн засаг хөгжлийн яам	Д.Эрдэнэбаяр	Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга	Эдийн засагч
5	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	М.Мэндбаяр	Ашигт малтмал газрын тосны газрын Нүүрсний судалгааны хэлтсийн дарга	Уул уурхайн инженер
6	Байгаль орчин аялал жуулчлалын яам	Д.Санчир	Хуулийн хэлтсийн ахлах шинжээч	Эрх зүйч
7	Хараат бус	Ц.Болдбаатар	Монголын дотоод аудиторуудын институтын Чанарын менежер	нягтлан бодогч
8	Хараат бус	Ө.Гэрэлт-Од	МУИС дэд проф. Бизнес консалтинг төвийн захирал	нягтлан бодогч
9	Хараат бус	Б.Чойжил	Монголын төмөр зам ТӨХК Боомтын төслийн менежер	нягтлан бодогч
10	Хараат бус	Б.Мөнхзаяа	Отгонтэнгэр их сургуулийн багш	Эрх зүйч
11	"Монголиан нейшнл коал корпорейшн" ХХК	М.Отгонбаяр	"Монголиан нейшнл коал корпорейшн" ХХК-ийн төлөөлөл	Геологич
12	"Монголиан нейшнл коал корпорейшн" ХХК	Д.Чинбат	"Монголиан нейшнл коал корпорейшн" ХХК-ийн төлөөлөл	Технологич

Хурал даргалагч С.Наранцогт: Хувьцаа эзэмшигчдэд нэр дэвшигчдийн жагсаалттай холбогдуулан асуух асуулт байна уу?

Асуулт: Хувьцаа эзэмшигч О.Эрдэнэбилэг: Нэр дэвшигчдийг ямар журмаар сонгон шалгаруулсан бэ? Ихэнх нь хуульч, эдийн засагчид байна, энэ хүмүүс "Багануур" ХК-ийн эрх ашгийн төлөө ажиллаж чадах уу?

Хариулт: Хурал даргалагч С.Наранцогт: "Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам"-д заасны дагуу "Багануур" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус болон төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүдийг сонгон шалгаруулах ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 06-18-ны өдрүүдэд нээлттэй зохион байгуулж шаардлага хангасан нэр дэвшигчдийн жагсаалтыг гаргасан болно.

Хурал даргалагч С.Наранцогт: Хурлын дэгийн дагуу хурлын үйл ажиллагаа 10 минут завсарлана. Энэ хугацаанд хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа гарган Тооллогын комисст өгөв.

Хурал даргалагч С.Наранцогт: Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар авсан санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Б.Хажидмаа танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Б.Хажидмаа:

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 02.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,150,526 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 12 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Санал өгсөн байдлыг үзвэл

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Зөвшөөрсөн	20,150,492.00	санал 100% хувь
Татгалзсан	-	санал 0.0% хувь
Түдгэлзсэн	-	санал 0.0% хувь

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 03.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,150,526 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 12 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Санал өгсөн байдлыг үзвэл

2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Зөвшөөрсөн	20,150,492.00	санал 100% хувь
Татгалзсан	-	санал 0.0% хувь
Түтгэлзсэн	-	санал 0.0% хувь

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 04.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,150,526 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 12 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Санал өгсөн байдлыг үзвэл

3. Ноогдол ашиг хуваарилах эсэх талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга

Зөвшөөрсөн	20,150,307.00	санал 99.999%	хувь
Татгалзсан	185.00	санал 0.001%	хувь
Түдгэлзсэн	-	санал 0.0%	хувь

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 05.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,150,526 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 12 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Санал өгсөн байдлыг үзвэл

4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Зөвшөөрсөн	20,150,492.00	санал 100%	хувь
Татгалзсан	-	санал 0.0%	хувь
Түдгэлзсэн	-	санал 0.0%	хувь

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 06.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,150,526 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 12 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Санал өгсөн байдлыг үзвэл

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.

Зөвшөөрсөн	20,150,307.00	санал 99.999%	хувь
Татгалзсан	-	санал 0.0%	хувь
Түдгэлзсэн	185.00	санал 0.001%	хувь

6. “Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа бүхий 251,692,320 саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцсон байна. Үүнээс ТУЗ-ын гишүүдийг сонгох кумулятив аргаар нийт саналын эрхийн 66.7%-аар ердийн гишүүдийг сонгох санал хураалт явуулж 12 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. /Санал хураалтын нэгдсэн дүнг хавсаргав/

Хүчингүй саналын хуудас байхгүй

Санал өгсөн байдлыг үзвэл:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах нэр бүхий ердийн гишүүдийг сонгосонд тооцсугай. Санал хураалтын дүн:

Б.Гэрлээ	20,153,747.0	санал
Ч.Дондогмаа	20,147,471.0	санал
И.Лувсанцэрэн	20,147,639.0	санал

Д.Эрдэнэбаяр	20,160,399.0	санал
М.Мэндбаяр	20,147,671.0	санал
Д.Санчир	20,147,471.0	санал
М.Отгонбаяр	20,150,137.0	санал
Д.Чинбат	20,149,401.0	санал

7. “Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа бүхий 251,692,320 саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцсон байна. Үүнээс ТУЗ-ын гишүүдийг сонгох кумулятив аргаар нийт саналын эрхийн 33.3%-аар хараат бус гишүүдийг сонгох санал хураалт явуулж 12 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. /Санал хураалтын нэгдсэн дүнг хавсаргав/
Хүчингүй саналын хуудас байхгүй
Санал өгсөн байдлыг үзвэл:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах нэр бүхий хараат бус гишүүдийг сонгосонд тооцсугай. Санал хураалтын дүн:

Ц.Болдбаатар	20,156,485.0	санал
Ө.Гэрэлт-Од	20,148,713.0	санал
Б.Чойжил	20,148,057.0	санал
Б.Мөнхзаяа	20,147,973.0	санал

Хурал даргалагч С.Наранцогт: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай хуралдаж дууслаа. Идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье.

Хурал 14:55 цагт дуусав.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



С.НАРАНЦОГТ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Хурал зохион байгуулах комиссын гишүүн



Б.Одгэрэл